

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 12 сарын 12-ны өдөр

Дугаар 349

Улаанбаатар хот

Хадгаламж, зээлийн хоршооноос төвлөрүүлэх
зохицуулалтын үйлчилгээний хөлсний
хэмжээг тогтоох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.5 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хадгаламж, зээлийн хоршооноос Санхүүгийн зохицуулах хороонд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг нэгдүгээр хавсралтаар, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тооцох аргачлалыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны “ХЗХ-ны зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 164 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Хадгаламж, зээлийн хоршоодоос жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг жил бүрийн 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хорооны дансанд төвлөрүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНООС ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ

Д/д	Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын үйлчилгээний төрөл	Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ	
		Жил бүр /хувиар/	Тухай бүр /төгрөгөөр/
1	Нийт хөрөнгөөс* тооцож, жил бүр төлөх зохицуулалтын үйлчилгээний хөлс	0.03 хувь* /доод хэмжээ нь 20,000 төгрөг, дээд хэмжээ нь 2,000,000 төгрөгбайна/	-
2	Оноосон нэр өөрчлөх	-	2,000,000
3	Хуулинд заасан бусад зөвшөөрөл олгох:		
	А. Санхүүгийн түрээсийн үйлчилгээ		150,000
	Б. Төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ	-	100,000
	В. Цахим төлбөр тооцооны төлөөлөгчөөр ажиллах үйлчилгээ		100,000
	-Хорооны тогтоолоор батлах бусад ажил, үйлчилгээ		-Хорооны тогтоолоор тухай бүр шийдвэрлэх
4	Үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болгосон гэрчилгээг нөхөн олгох, солих	-	100,000
5	Дүрэм болон бусад мэдээллийг Хорооны архиваас хуулбарлан авах	-	1,000 /нэг нүүр/
6	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх	-	100,000

*-жилийн эцсийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан дахь нийт хөрөнгийн дүнгээс тооцно

*-тогтоосон хугацаанд зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд төвлөрүүлээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.5 хувийн алданги тооцно.

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын үйлчилгээний хөлсийг жил бүр төвлөрүүлэх болон тухай бүр төвлөрүүлэх гэж 2 ангилна.

1. Жил бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дараах байдлаар тооцно:

ХЗХ-ны зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тухайн ХЗХ-ны жилийн эцсийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан дахь нийт хөрөнгийн дүнгээс 0,03 хувиар тооцно. Энэхүү зохицуулалтын үйлчилгээний хөлсний доод хэмжээг 20 000, дээд хэмжээг 2 000 000 төгрөг байхаар тогтоолын нэгдүгээр хавсралтад заасан.

Жишээ 1: “А” ХЗХ нь нийт 50 000 000 төгрөгийн хөрөнгөтэй гэвэл тооцооллын дагуу 15000 төгрөгийг төлөхөөр байгаа хэдий ч зохицуулалтын үйлчилгээний хөлсний доод хэмжээ болох 20 000 төгрөгийг төлнө.

Жишээ 2: “Б” ХЗХ нь нийт 1 035 000 000 төгрөгийн хөрөнгөтэй гэвэл тооцооллын дагуу 310 500 төгрөгийн зохицуулалтын үйлчилгээний хөлс төлнө.

Жишээ 3: “В” ХЗХ нь нийт 7 000 000 000 төгрөгийн хөрөнгөтэй гэвэл тооцооллын дагуу 2 100 000 төгрөгийг төлөхөөр байгаа хэдий ч зохицуулалтын үйлчилгээний хөлсний дээд хэмжээ болох 2 000 000 төгрөгийг төлнө.

2. Тухай бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг дараах байдлаар тооцно.

ХЗХ-ны оноосон нэрийг өөрчлөх, тусгай зөвшөөрлийн гэрчилгээг үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болгосон тохиолдолд нөхөн олгох, солиход болон хуулинд заасан бусад зөвшөөрөл олгох зэрэг нэг удаагийн шинжтэй үйлчилгээ үзүүлэхэд авах хөлсийг журмын нэгдүгээр хавсралтаар тогтоосон.

_____оОо_____